ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ГАЗАР

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНХААРУУЛГА МЭДЭЭЛЭЛ /SAFETY BULLETIN/

2025 оны 02 сарын 24 өдөр № 01

АНХААРУУЛГА ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Хиймэл дагуулын навигацийн систем (Global navigation satellite system-GNSS)-ийн дохио, сигналын чанар, найдваржилтай холбоотой автомат хамааралтай ажиглалтын ADS-B системийг нислэгийн хөдөлгөөний ажиглалтын удирдлагад ашиглах үед агаарын хөлгийн давхар дүрслэл AIRCON2100 автомат системд үүсэх тохиолдол буурахгүй байгаа тул тус үл тохирлыг залруулах арга хэмжээ авах хүртэлх хугацаанд дараах зааварчилгааг мөрдөж ажиллана уу. Үүнд:

1. “GPS lost” нөхцөл байдал үүссэн үед ADS-B системийн нарийвчлал алдагдан автоматжуулсан систем дээрх агаарын хөлгийн дүрслэл нь (**Δ**) болон (◊**s**) тэмдэгтээр ялгаатай байрлалд салж дүрслэгдсэн тохиолдолд ажиглалтын хоёрдогч радиолокаторын - (◊**s**) дүрслэлийн мэдээлэлд тулгуурлан нислэгийн хөдөлгөөний удирдлагыг гүйцэтгэнэ.

ТЭМДЭГЛЭГЭЭ	ТАЙЛБАР
△	GPS lost-с шалтгаалсан ADS-B системийн нарийвчлал алдагдсан
◇s	GPS lost-с шалтгаалсан ADS-B системийн нарийвчлал алдагдсан үед MSSR хэвийн ажиллагаатай
△s	ADS-B болон MSSR хэвийн ажиллагаатай

2. Дээрх нөхцөл байдал үүссэн үед нислэгийн хөдөлгөөний удирдагч нь ахлах нислэгийн хөдөлгөөний удирдагч болон ерөнхий нислэгийн хөдөлгөөний удирдагчид заавал мэдэгдэх ба ерөнхий нислэгийн хөдөлгөөний удирдагч бүрэн хяналт тавьж ажиллана.

3. ЭЕНХУ нь дээрх нөхцөл байдлын талаар НХНАА-ны Ээлжийн инженерт /1724 дугаарт/ мэдээлэх ба мэдээлэлд дараах агуулгыг багтаасан байна.
   a. Агаарын хөлгийн дуудлага;
   b. Давхар дүрслэгдэж эхэлсэн цаг (UTC);
   c. Давхар дүрслэл үүсэж буй байршил.

4. Агаарын хөлгүүдэд давхар дүрслэл үүсэж буй талаар НХҮА-ны Ээлжийн ерөнхий нислэгийн хөдөлгөөний удирдагч нар нэгдсэн бүртгэл хийж, тэмдэглэл хийнэ. Үүнд дараах мэдээллүүд орно:
   a. Огноо, цаг (UTC);
   b. Давхар дүрслэл эхэлсэн сектор;
   c. Давхар дүрслэгдэж буй агаарын хөлгийн дуудлага;
   d. Агаарын зам;

Утас: 976-88974030
sqmd@mcaa.gov.mn

e. Давхар дүрслэгдэж буй агаарын хөлгийн төрөл/бүртгэлийн дугаар;
f. Давхар дүрслэгдэж буй агаарын хөлгийн нислэгийн түвшин.

5. “GPS lost” нөхцөл байдлаас шалтгаалан автомат системд давхар дүрслэл үүссэн тухай бүр ээлжийн ахлахын хяналтын хуудсаар Аюулгүй байдал, чанарын удирдлагын газарт мэдээлнэ.

6. НХҮА-ны дарга нь долоо хоног бүрийн давхар дүрслэлийн талаарх мэдээллийг албаны “Аюулгүй байдлын баг”-аар хэлэлцүүлэн мэдээллийг Аюулгүй байдал, чанарын удирдлагын газарт хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд НХҮА-ны дарга нь НХНАА-ын аюулгүй байдлын багийг оролцуулан хуралдааныг хийнэ.

<u>ТАЙЛБАР:</u> 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд НХҮА-аас НХНАА-нд хүргүүлсэн 15 удаагийн давхар /хуурамч/ дүрслэл илэрсэн тухай аюулгүй байдлын мэдээлэл болон НХНАА-аас хийсэн үзлэг шалгалтын ажлын тайланд үндэслэн АБЧУГ-аас тус аюулгүй байдлын зааварчилгааг боловсруулан гаргасан болно.

Утас: 976-88974030
sqmd@mcaa.gov.mn